



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/265

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 35 дугаар зөвлөмжийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/ барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах (БСШУСЯ/201902088)-ийг 956,602,401 (есөн зуун тавин зургаан сая зургаан зуун хоёр мянга дөрвөн зуун нэг) төгрөгөөр Цагаан бургалтай ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100585